



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/МБ

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тасралтгүй тэжээлийн систем UPS болон батерей нийлүүлэх (Улаанбаатар, Хөвсгөл, Төв, Хэнтий, Өмнөговь, Сүхбаатар аймаг)" ИНУТ/ХО/НТШ/Б-21/21 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Д.Галт	Иргэний нисэхийн үндэсний төвийн Гэрэл суулт, цахилгаан хангалтын албаны ерөнхий инженер
Гишүүд:	Ц.Батмөнх	Иргэний нисэхийн үндэсний төвийн Гэрэл суулт, цахилгаан хангалтын Албаны ахлах инженер
	Г.Хишигдэлгэр	Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны мэргэжилтэн
	Б.Болормаа	Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч
	Б.Энхтайван	Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын үндсэн хөрөнгө хариуцсан нярав

2. Гэрээний хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолт холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган

хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлэхийг бараа хүлээн авах комисс (Д.Галт)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН